

Deutsch




Монгол

Niederösterreich (Умард
Австри) муж улс дахь
үндсэн хангамж

Орогнол хүсэгчид ба бусад албадан гаргах
боломжгүй харь хүмүүст зориулав

ALLGEMEINES UND ZUSTÄNDIGKEITEN


1. Warum gibt es die Grundversorgung?

 Um insbesondere hilfsbedürftigen Asylwerbern in Österreich ein menschenwürdiges Leben zu ermöglichen.

Die Grundversorgung ist im **NÖ Grundversorgungsgesetz** geregelt.


Das **NÖ Grundversorgungsgesetz** wurde im **LGBl. 9240 verlautbart**. Im Internet finden Sie dieses Gesetz unter <http://www.ris.bka.gv.at> in der Rubrik Landesrecht - geltende Fassung Niederösterreich - mit dem Suchwort „NÖ Grundversorgungsgesetz“.

2. Wer übernimmt für meine Grundversorgung die Kosten?

 Ihre Versorgung wird vom **Land Niederösterreich** und dem **Bundesministerium für Inneres** aus Steuermitteln der österreichischen Bevölkerung finanziert.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ХЭН ЮУГ ХАРИУЦДАГ ТУХАЙ


1. Үндсэн хангамжийн зорилго нь юу вэ?

 Юуны түүрүнд Австри улсад байгаа, туслалцаа хэрэгцээтэй орогнол хүсэгчдэд хүний ёсоор амьдрах бололцоог бүрдүүлж өгөх.


Үндсэн хангамж нь **NÖ Grundversorgungsgesetz (Niederösterreich муж улсын үндсэн хангамжийн тухай хууль)**-ээр зохицуулагдана.

Nö Grundversorgungsgesetz нь **LGBl. 9240-д нийтэд сонордуулагдсан** бөгөөд та бүхэн энэхүү хуулийг интернетэд <http://www.ris.bka.gv.at> хаягаар орж, Landesrecht - geltende Fassung Niederösterreich хэсэгт „Nö Grundversorgungsgesetz“ гэсэн хайх үгээр олж үзэж болно.


2. Миний үндсэн хангамжийн зардлыг хэн даах вэ?

 Таны хангамжийг **Land Niederösterreich (Умард Австри муж улс)** ба **Bundesministerium für Inneres (Холбооны дотоод явдлын яам)** Австрийн хүн амын татварын мөнгөнөөс санхүүжүүлнэ.

3. Wer entscheidet in NÖ über meine Grundversorgung?


 Über die Gewährung der Grundversorgung entscheidet im Namen der NÖ Landesregierung die **Koordinationsstelle für Ausländerfragen**.

4. Wie finde ich die Koordinationsstelle?


 **Koordinationsstelle für Ausländerfragen** beim Amt der NÖ Landesregierung:
3109 St. Pölten, Landhausplatz 1, Haus 7a,
Tel.Nr.: 02742/9005/12994, Fax: 02742/9005/15640,
E-Mail: post.ivw2fluechtlingshilfe@noel.gv.at.
Weitere Informationen finden Sie unter
<http://www.noel.gv.at/Gesellschaft-Soziales/Soziale-Dienste-Beratung/Fluechtlingshilfe.html>.

Die Wegbeschreibung zur Koordinationsstelle für Ausländerfragen entnehmen Sie der Seite 4.

3. Nö муж улсад миний үндсэн хангамжийн талаар шийдвэрийг хэн гаргах вэ?

 Үндсэн хангамж үзүүлэх эсэхийг **Koordinationsstelle für Ausländerfragen** (Гадаад иргэдийн асуудлыг хариуцан зохицуулах алба) Нө-ийн засгийн газрын нэрийн өмнөөс шийдвэрлэнэ.

4. Гадаад иргэдийн асуудлыг хариуцан зохицуулах албыг би яаж олж очих вэ?

 Нө-ийн засгийн газрын тамгын газрын дэргэдэх **Koordinationsstelle für Ausländerfragen**:
3109 St. Pölten, Landhausplatz 1, Haus 7a,
Утас: 02742/9005/12994, Факс: 02742/9005/15640,
E-Mail: post.ivw2fluechtlingshilfe@noel.gv.at.
Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи вэб хаягаар орж үзнэ үү:
<http://www.noel.gv.at/Gesellschaft-Soziales/Soziale-Dienste-Beratung/Fluechtlingshilfe.html>.

Koordinationsstelle für Ausländerfragen руу очих замыг 4-р хуудсаас олж үзнэ үү.

Karte – Fußweg vom Bahnhof zur Koordinationsstelle für Ausländerfragen im Regierungsviertel



Газрын зураг – галт тэрэгний буудлаас Regierungsviertel (Засгийн газрын дүүрэг)-д орших Koordinationsstelle für Ausländerfragen руу явган очих зам

Karte – Genauer Standort der Koordinationsstelle für Ausländerfragen beim Amt der NÖ Landesregierung im Regierungsviertel, Landhausplatz 1, Haus 7a




Газрын зураг – Nö муж улсын засгийн газрын тамгын газрын дэргэдэх Koordinationsstelle für Ausländerfragen-ны оршин буй тодорхой байрлал: Regierungsviertel (Засгийн газрын дүүрэг), Landhausplatz 1, Haus 7a

Bezirke in Niederösterreich

D = Diakonie

C = Caritas

Niederösterreich муж улс дахь тойргууд



5. Von wem werde ich betreut? – Hilfe bei Fragen!



Wenn Sie in den **blau** gekennzeichneten Bezirken wohnen, ist die **Caritas** für Sie zuständig, in den **rot** gekennzeichneten ist es die **Diakonie**. Diese **Betreuungsorganisationen** besuchen Sie auch regelmäßig in den organisierten Quartieren (Pensionen). Wenn Sie Fragen haben, wenden Sie sich an die zuständigen Betreuer.

5. Намайг хэн халамжлах вэ? – Асуулт гарвал хэнээс туслалцаа авах тухай!



Хэрвээ та хөх өнгөөр тэмдэглэсэн дүүргүүдэд амьдарч байгаа бол таныг **Caritas** хариуцна. Улаан өнгөөр тэмдэглэсэн дүүргүүдэд бол **Diakonie** хариуцна. Энэхүү халамжийн байгууллагууд нь таныг зохион байгуулалттай (нийтийн) байранд тань тогтмол эргэж тойрч байх болно. Хэрэв таньд асуулт гарвал өөрийг тань хариуцсан халамжлагчдаа хандаарай.

6. Wo sind die Diakonie und Caritas erreichbar?



Caritas Wr. Neustadt: Wiener Straße 56,
2700 Wr. Neustadt, Tel.Nr.: 02622/83020,
Fax: DW 66, E-Mail: post-mfb-noe@caritas-wien.at.

Caritas Korneuburg: Hauptplatz 6-7, 2100 Korneuburg,
Tel.Nr.: 02262/62355, Fax: DW 50,
E-Mail: post-mfb-noe@caritas-wien.at.

Weitere Informationen finden Sie unter <http://www.caritas-wien.at/mobilebetreuung.htm>.

Diakonie St. Pölten: Josefstraße 5/4, 1. Stock, 3100 St. Pölten,
Tel.Nr.: 02742/21438, Fax: DW 5,
E-Mail: noewe@diakonie.at.

Weitere Informationen finden Sie unter
<http://fluechtlingsdienst.diakonie.at/goto/de/was/Beratung/mobile-betreuungsstelle-niederoesterreich-west/besondere-aktivitaeten>.

LEISTUNGEN

7. Wer kann Grundversorgung bekommen?



Hilfsbedürftige Asylwerber und bestimmte andere **nicht abschiebbare hilfsbedürftige Fremde**.

Hilfsbedürftig ist, wer nicht selbst für seinen **Lebensunterhalt (Wohnung, Essen, Bekleidung)** sorgen kann. Genauere Information erhalten Sie bei der Caritas oder Diakonie.

6. Diakonie ба Caritas – тай яаж холбоо барих вэ?



Caritas Wr. Neustadt: Wiener Straße 56,
2700 Wr. Neustadt, Утас: 02622/83020,
Факс: сүүлийн хоёр тоо нь 66, E-Mail: post-mfb-noe@caritas-wien.at.

Caritas Korneuburg: Hauptplatz 6-7, 2100 Korneuburg,
Утас: 02262/62355, Факс: сүүлийн хоёр тоо нь 50,
E-Mail: post-mfb-noe@caritas-wien.at.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи вэб хаягаар орж үзнэ үү:
<http://www.caritas-wien.at/mobilebetreuung.htm>.

Diakonie St. Pölten: Josefstraße 5/4, 1. Stock (1-р давхар),
3100 St. Pölten,
Утас: 02742/21438, Факс: сүүлийн тоо нь 5,
E-Mail: noewe@diakonie.at.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи вэб хаягаар орж үзнэ үү:
<http://fluechtlingsdienst.diakonie.at/goto/de/was/Beratung/mobile-betreuungsstelle-niederoesterreich-west/besondere-aktivitaeten>.

ТЭТГЭЛГҮҮД

7. Хэн үндсэн хангамжинд орж болох вэ?



Тусламж шаардлагатай орогнол хүсэгчид ба бусад албадан гаргах боломжгүй, тусламж шаардлагатай тодорхой харь хүмүүс. Амьдралын хэрэгцээгээ (орон байр, хоол унд, хувцас) хангах чадваргүй хүнийг тусламж шаардлагатайд тооцно. Caritas ба Diakonie-гаас тодорхой мэдээлэл авна уу.

8. Welche Grundversorgungsleistungen kann ich bekommen?

Die wichtigsten Leistungen sind:



- **Unterbringung**
- **Verpflegung**
- **Krankenversorgung**
- **Bekleidungshilfe (max. € 150,- pro Jahr)**
- **Schulbedarfshilfe für schulpflichtige Schulkinder (max. € 200,- pro Jahr und Kind)**
- **Taschengeld (max. € 40,- pro Person und Monat)**

Bitte beachten Sie, dass die Leistungen je nach Unterbringungsform (organisiert oder privat) verschieden sein können.

Bezüglich sonstiger möglicher Leistungen oder anderer Fragen setzen Sie sich mit Ihrer Betreuungsorganisation (Caritas oder Diakonie) in Verbindung.

9. Bekomme ich Taschengeld?



Grundsätzlich können Sie **€ 40,- pro Person und Monat** bekommen, wenn Sie in einer **organisierten Unterkunft** (Gasthaus, Pension, Heim) untergebracht sind und dort kein Verpflegungsgeld ausbezahlt wird.

8. Надад үндсэн хангамжийн хүрээнд ямар ямар хангамж үзүүлэх вэ?

Хамгийн чухал хангамжууд:



- **Орон байр**
- **Хоол хүнс**
- **Эмнэлгийн хангамж**
- **Хувцас авахад үзүүлэх тусламж (жилд дээд тал нь € 150,-)**
- **Сургуулийн насны хүүхдүүдэд зориулж хичээлийн хэрэгсэл авахад үзүүлэх тусламж (хүүхэд тутамд жилд дээд тал нь € 200,-)**
- **Халаасны мөнгө (нэг хүнд сард дээд тал нь € 40,-)**

Орон байрны хэлбэрээс (зохион байгуулалттай, эсвэл хувийн) шалтгаалан хангамжууд нь өөр өөр байж болохыг анхаарна уу.

Үзүүлж болох бусад хангамжуудын талаар болон өөр асуудлуудын талаар өөрийн хариуцагч халамжийн байгууллагадаа (Caritas ба Diakonie) хандана уу.

9. Би халаасны мөнгө авах уу?



Хэрвээ та зохион байгуулалттай орон байранд (нийтийн байр, зочид буудал г.м.) амьдарч байгаа бөгөөд тэндээсээ хангамжийн мөнгө авдаггүй бол **нэг хүн сард € 40,- авдаг зарчимтай.**

10. Kann ich aus der Grundversorgung entlassen werden?



Ja! Insbesondere

- **Drohungen, Gewalttätigkeiten, unzumutbares Verhalten in Quartieren**
- **ausreichendes eigenes Einkommen**
- **Vermögen (z.B. Besitz eines Autos)**
- **rechtskräftig abgeschlossene Asylverfahren (sowohl positive als auch negative Entscheidungen)**
- **nicht genehmigter Wechsel des Quartiers**

können zur Entlassung aus der Grundversorgung führen.

11. Was kann ich tun, wenn ich aus der Grundversorgung entlassen werde?



- Sie können die zuständige Betreuungsorganisation aufsuchen, um eine Lösung des Problems zu erarbeiten.
- Wenn Sie noch Asylwerber sind, können Sie von der Koordinationsstelle für Ausländerfragen eine schriftliche Erledigung verlangen.

10. Би үндсэн хангамжаас хасагдаж болох уу?



Тийм! Ялангуяа доорхи зүйлүүд үндсэн хангамжаас хасагдахад хүргэж болно:

- **Заналхийлэх, хүч хэрэглэх, орон байранд зүй бусаар авирлах**
- **Хүрэлцээтэй хувийн орлого**
- **Эд хөрөнгө (жишээлбэл автомашин эзэмших)**
- **Орогнол хүссэн хэрэг тань хуулийн хүчин төгөлдөр шийдэгдсэн бол (нааштай буюу татгалзсан шийдвэрийн аль аль нь)**
- **Зөвшөөрөлгүйгээр орон байраа солих**

11. Би үндсэн хангамжаас хасагдсан тохиолдолд явал зохих вэ?



- Та тухайн асуудлыг шийдвэрлэх талаар өөрийн хариуцагч халамжийн байгууллагатайгаа ярилцаж болно.
- Хэрэв та орогнол хүсэгч хэвээрээ байгаа бол Koordinationsstelle für Ausländerfragen-аас хэргийг тань бичгээр шийдвэрлэж өгөхийг шаардаж болно.

WOHNEN

12. Welche Unterbringungsarten gibt es?



- Unterbringung in **organisierten Unterkünften** (Unterbringung in einem Gasthaus, Pension, Heim)
- Unterbringung in **privaten Unterkünften** (Mietzuschuss für eine Wohnung)

13. Habe ich Anspruch auf eine bestimmte Unterkunft oder Unterbringungsart?



Nein!

Angebote **organisierte Unterkünfte** (Pension) **müssen Sie annehmen**. Ablehnung kann zum Verlust der gesamten Grundversorgung führen. Jeder gewünschte Wechsel in eine andere Unterkunft muss **vorher** von der Koordinationsstelle **genehmigt** werden.

14. Kann ich jederzeit die Unterkunft wechseln?



Nein!

Jeder Wechsel ist von der Koordinationsstelle für Ausländerfragen **vorher** zu **genehmigen**. Auch privater Wohnungswechsel muss gemeldet und genehmigt werden. Setzen Sie sich diesbezüglich im Vorhinein mit Ihrer Betreuungsorganisation in Verbindung.

ОРОН БАЙР

12. Оршин суулгах ямар хэлбэрүүд байдаг вэ?



- Зохион байгуулалттай байрнуудад оршин суулгах (зочид буудал, хөлсний байр, нийтийн байр)
- Хувийн байрнуудад оршин суулгах (байрны хөлсөнд мөнгөн нэмэлт өгнө)

13. Би тодорхой нэг байранд оршин суух шаардлага тавих эрхтэй юу?



Үгүй!

Танд санал болгосон зохион байгуулалттай байрыг та заавал хүлээн авах ёстой. Үгүй бол үндсэн хангамжаа ч бүхэлд нь алдаж болзошгүй юм. Байраа өөр байраар солиход Koordinationsstelle für Ausländerfragen **эхлээд зөвшөөрөл өгөх** ёстой.

14. Би хэдийд ч байраа сольж болох уу?



Үгүй!

Байр солих бүрд Koordinationsstelle für Ausländerfragen **эхлээд зөвшөөрөл өгөх** ёстой. Хувиараа байраа сольсон ч гэсэн мэдэгдэж, зөвшөөрөл авах шаардлагатай. Үүнтэй холбогдуулан эртнээс өөрийн хариуцагч халамжийн байгууллагатайгаа холбоо барина уу.

15. Kann ich mir ein beliebiges Bundesland aussuchen?



Nein!

Mit dem Transfer aus der Erstaufnahmestelle (EAST Traiskirchen, Thalham) werden Sie einem Bundesland zugewiesen. Dieses Bundesland ist grundsätzlich für Sie zuständig. Ein Wechsel im Rahmen der Grundversorgung ist nur nach Genehmigung beider betroffenen Bundesländer möglich. Wechseln Sie ohne Genehmigung das Bundesland, können Sie Ihren Anspruch auf Grundversorgung verlieren. Informationen dazu können Sie von Ihrer Betreuungsorganisation erhalten.

16. Was muss ich bei Privatunterkünften berücksichtigen?



Wichtig!

Sie haben **keinen Anspruch auf Geld für eine Privatunterkunft** und brauchen daher vorher eine **Genehmigung** von der Koordinationsstelle für Ausländerfragen. Nicht genehmigte Privatunterkünfte müssen Sie vollständig **selbst finanzieren**. Die entsprechenden Unterlagen und Beratung für einen Wechsel bekommen Sie bei der Caritas und Diakonie.

15. Би муж улсуудаас дуртайгаа сонгож болох уу?



Үгүй!

Анхлан хүлээн авах газраас (EAST Traiskirchen, Thalham) таныг муж улсуудын нэгэнд хуваарилна. Энэхүү муж улс нь зарчмын хувьд таныг хариуцна гэсэн үг. Үндсэн хангамжийн хүрээнд муж улсаа солиход тухайн хоёр муж улсын зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай. Хэрвээ та зөвшөөрөлгүйгээр муж улсаа соливол үндсэн хангамжаас хасагдаж болзошгүй юм. Энэ тухай мэдээллийг өөрийн хариуцагч халамжийн байгууллагаасаа авна уу.

16. Хувийн орон байранд би юуг анхаарвал зохих вэ?



Чухал!

Та хувийн байр хөлслөх мөнгө шаардах эрхгүй учир эхлээд Koordinationsstelle für Ausländerfragen-аас **зөвшөөрөл** авах ёстой. Зөвшөөрөлгүй хөлслөсөн хувийн орон байраа та бүхэлд нь **өөрөө санхүүжүүлнэ**. Caritas ба Diakonie-гаас зохих бичиг баримт, зөвлөгөөг авна уу.

17. Wie viel Geld bekomme ich für genehmigte Privatunterkünfte?



- Als **Einzelperson** bekommen Sie pro Monat maximal € 110,- Mietzuschuss und € 180,- Verpflegungsgeld.
- Als **Familie** bekommen Sie pro Monat maximal € 220,- Mietzuschuss, € 180,- Verpflegungsgeld für jeden Erwachsenen und € 80,- Verpflegungsgeld für jeden Minderjährigen (bis 18 Jahre).

Bitte beachten Sie, dass Sie mit dieser Unterstützung Ihre gesamten Lebenskosten bestreiten müssen (Strom, Heizung, Lebensmittel, Fahrkarten, Möbel und ähnliches kosten viel Geld)!

18. Gelten für mich Hausordnungen?



Ja! Für organisierte Unterkünfte gibt es eine Hausordnung der Koordinationsstelle für Ausländerfragen.

Die Nichtbeachtung dieser Hausordnung kann zur **Entlassung aus der Grundversorgung** führen.

Bei Ihrem Einzug in eine Grundversorgungsunterkunft sollten Sie die Hausordnung in einer Ihnen verständlichen Sprache erhalten und diese auch unterschreiben. In Ihrem Interesse sollten Sie Ihre Pflichten aus der Hausordnung kennen und beachten.

17. Зөвшөөрөлтэй хувийн орон байранд зориулж би хэр их мөнгө авах вэ?



- Ганц бие хүн сард байрны хөлсөнд дээд тал нь € 110,- мөн хоол хүнсэнд дээд тал нь € 180,- авна.
- Гэр бүл бол насанд хүрсэн гэр бүлийн гишүүн болгон сард байрны хөлсөнд дээд тал нь € 220,- мөн хоол хүнсэнд дээд тал нь € 180,- авна. Насанд хүрээгүй (18 нас хүрээгүй) гэр бүлийн гишүүн болгон сард хоол хүнсэнд дээд тал нь € 80,- авна.

Энэ тэтгэлгээр та амьдралын бүхий л зардлаа төлөх ёстой гэдгийг анхаарна уу (Цахилгаан, халаалт, хоол хүнс, зорчих билет, тавилга гэх мэт зүйл маш их мөнгө шаардана)!

18. Байрны дотоод дүрэм надад бас үйлчлэх үү?



Тийм! Зохион байгуулалттай байрнуудад Koordinationsstelle für Ausländerfragen-аас гаргасан байрны дүрэм үйлчилдэг.

Энэхүү байрны дүрмийг үл тоомсорловол **үндсэн хангамжаас хасагдаж болзошгүй** юм.

Үндсэн хангамжийн орон байранд нүүж орохдоо та байрны дүрмийг өөрт тань ойлгомжтой хэл дээр гардан авч, гарын үсгээ зурах ёстой. Та өөрийн эрх ашгийн үүднээс байрны дүрэмд заасан үүргүүдээ мэдэж, тэдгээрийг баримталж байвал зохино.

19. Wie lange darf ich von einer organisierten Unterkunft abwesend sein?



Sie haben Ihren Quartiergeber über Abwesenheiten grundsätzlich zu informieren. Bei mehrmaliger Abwesenheit wird von der Koordinationsstelle für Ausländerfragen Ihre **Hilfsbedürftigkeit in Frage gestellt**. Bei längerer Abwesenheit als 3 Tage erfolgt automatisch die Abmeldung von der Grundversorgung (außer bei gemeldetem Aufenthalt im Krankenhaus).

RECHTLICHE ANGELEGENHEITEN

20. Was wird mir bei behördlichen Ladungen empfohlen?



Ladungen sollten in Ihrem Interesse unbedingt befolgt werden!!!!

Ansonsten kann es zu Nachteilen im Asylverfahren oder zur **Einstellung der Grundversorgung** führen. Werden Sie von **Asylbehörden geladen**, werden Ihnen die **Fahrtkosten ersetzt**. Setzen Sie sich bei Ladungen dringend mit der für Sie zuständigen Betreuungsorganisation in Verbindung.

19. Би зохион байгуулалттай орон байрандаа хэр удаан эзгүй байж болох вэ?



Та эзгүйгээ байрны даргадаа үргэлж мэдэгдэх ёстой. Удаа дараалан эзгүй байвал Koordinationsstelle für Ausländerfragen танд үнэхээр **тусламж шаардлагатай гэдэгт эргэлзэхэд хүрнэ**. 3-аас илүү хоногоор эзгүй байвал үндсэн хангамжаас шууд хасна (эмнэлэгт хэвтэж, түүнийгээ мэдэгдсэн бол эзгүй байсанд тооцохгүй).

ЭРХ ЗҮЙН АСУУДЛУУД

20. Албан газруудаас дуудлага ирэхэд би яавал зохих вэ?



Та өөрийн эрх ашгийн үүднээс дуудлагуудад заавал очвол зохино!!!!

Эсрэг тохиолдолд орогнол хүссэн хэрэгт тань муугаар нөлөөлөх буюу үндсэн хангамжийг тань таслан зогсоход ч хүргэж болзошгүй юм. **Орогнол хүссэн хэргүүдийг хариуцсан албан газруудаас дуудагдвал замын зардлыг тань нөхөн олгоно**. Дуудлага ирвэл халамжийн байгууллагатайгаа яаралтай холбоо бариарай.

21. Darf ich in Österreich arbeiten?



Auch als Asylwerber unterliegen Sie dem Ausländerbeschäftigungsgesetz und **brauchen eine Beschäftigungsbewilligung.**

Eigenes Einkommen kann Auswirkungen auf die Höhe Ihrer Grundversorgung haben. Wenn Sie arbeiten und selbst Geld verdienen, müssen Sie dies aufgrund einer gesetzlichen Verpflichtung sofort der Koordinationsstelle für Ausländerfragen melden. Kommen Sie dieser Verpflichtung nicht nach, kann dies Auswirkungen auf die Art Ihrer Unterbringung haben und ist eine Strafe möglich.

22. Wo gibt es für mich einen Rechtsbeistand?



Es gibt mehrere Stellen und Vereine, die Sie im Asylverfahren begleiten. Die diesbezüglichen **Kontaktadressen** erhalten Sie über Ihre **Betreuungsorganisationen.**

23. Was soll ich der Koordinationsstelle unverzüglich melden?



Wichtig!
Insbesondere Änderung der Familienverhältnisse, Beschäftigung, Vermögen (z.B. Auto), Einkommen und Wohnungswechsel müssen gemeldet werden.

Wenn Sie das nicht tun, ist das strafbar und kann außerdem Auswirkungen auf die Grundversorgung haben (z.B. die teilweise oder gesamte Einstellung der Geldleistungen durch die Koordinationsstelle für Ausländerfragen).

21. Би Австрид ажил хийж болох уу?



Та орогнол хүсэгчийн хувьд Гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэх тухай хуулинд мөн адил захирагдах бөгөөд **хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах ёстой.**

Хувийн орлого нь үндсэн хангамжийн хэмжээ хязгаарт нөлөө үзүүлнэ. Хэрэв та ажил хийж, өөрөө мөнгө олж байгаа бол үүнийгээ хууль ёсны үүргийнхээ дагуу Koordinationsstelle für Ausländerfragen-нд даруй мэдэгдэх ёстой. Энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд таны оршин суулгах хэлбэрийг өөрчлөх буюу танд торгууль ноогдуулж болох юм.

22. Би хаанаас эрх зүйн туслалцаа авч болох вэ?



Орогнол хүсэх хэрэгт таныг дагалдан дэмжих олон газрууд болон нийгэмлэгүүд байдаг. Тэдгээртэй **холбоо барих хаягийг** өөрийн **халамжийн байгууллагаасаа** авна уу.

23. Би Гадаад иргэдийн хэргийг хариуцан зохицуулах албанд юу юуг даруй мэдээлвэл зохих вэ?



Чухал!
Ялангуяа гэр бүлийн байдалд орсон өөрчлөлтүүд, хөдөлмөр эрхлэлт, эд хөрөнгө (жиш. автомашин), орлого, мөн байр солих явдал, эдгээрийг мэдэгдэх шаардлагатай.

Хэрэв та эдгээрийг мэдэгдээгүй бол хууль зөрчиж байгаа хэрэг бөгөөд түүнээс гадна энэ нь үндсэн хангамжинд тань нөлөө үзүүлж болзошгүй юм (жиш. Koordinationsstelle für Ausländerfragen-аас мөнгөн тэтгэлгийг тань хэсэгчлэн буюу бүхэлд нь хасах).

GESUNDHEIT

24. Bekomme ich medizinische Versorgung?



Sie werden grundsätzlich bei der Niederösterreichischen Gebietskrankenkasse **krankenversichert**. Die unbedingt **notwendige Behandlung von Krankheiten oder Notfällen** sollte jedenfalls gewährleistet sein.

25. Was ist wichtig, wenn ich ein Kind bekomme?



Erkundigen Sie sich beim Arzt über den **kostenlosen Mutter-Kind-Pass**. Halten Sie im eigenen Interesse die darin vorgegebenen **Untersuchungen** im angegebenen Zeitraum genau ein, um die Gesundheit Ihres Kindes sicherzustellen.



Die **Geburt** Ihres Kindes sollten Sie sofort dem Quartiergeber oder Ihrer Betreuungsperson **melden**, damit die Aufnahme Ihres Kindes in die Grundversorgung geprüft werden kann.

Эрүүл мэнд

24. Эмнэлгийн хангамжийг би хэрхэн авах вэ?



Ерөнхийдөө та Niederösterreich муж улсын Gebietskrankenkasse (орон нутгийн эрүүл мэндийн даатгал)-д **эрүүл мэндийн даатгалтай** байна. **Өвчин туссан буюу золгүй явдалд өртсөн тохиолдолд зайлшгүй шаардлагатай эмчилгээ ямар ч байсан хангагдана.**

25. Би хүүхэдтэй болвол юу чухал вэ?



Эмчээсээ **үнэгүй өгдөг Mutter-Kind-Pass (эх нялхсын паспорт)-ны** талаар асуугаарай. Та өөрийн ашиг сонирхлын үүднээс хүүхдийнхээ эрүүл мэнд бойжилтыг хангахын тулд тэрхүү **паспорто**нд тэмдэглэгдсэн **эмчийн үзлэгүүдийг** цаг тухайд нь хийлгэж байгаарай.




Хүүхдээ **төрсөн тухай** байрныхаа даргад буюу халамжлагчдаа даруй **мэдэгдэх** хэрэгтэй. Ингэснээр хүүхдийг тань мөн үндсэн хангамжинд авах эсэхийг шалгах болно.

26. Sind Krankentransporte kostenlos?



Ein Transport ins nächstliegende Krankenhaus erfolgt **nur dann kostenlos**, wenn aus medizinischer Sicht ein liegender Transport (Tragsessel) erforderlich war. Dies muss ärztlich verordnet sein. Ist dies nicht der Fall, müssen Sie möglicherweise die Kosten selbst zahlen.



SONSTIGES

27. Darf ich ein Auto besitzen?



Der Besitz eines Autos kann wegen des dafür erforderlichen finanziellen Aufwandes Auswirkungen auf die Hilfsbedürftigkeit und damit auf die Höhe der Grundversorgung haben und ist **meldepflichtig!**

28. Können meine Kinder in die Schule gehen?




Kinder zwischen 6 und 15 Jahren **müssen** in Österreich eine Schule besuchen. Erkundigen Sie sich bei der für Sie zuständigen Betreuungsorganisation über einen möglichen **Schulbedarfszuschuss**.

26. Өвчтөн тээвэрлэлт үнэгүй юу?



Өвчтөнийг зайлшгүй хэвтээгээр нь (зөөрийн сандалд) тээвэрлэх **шаардлагатай тохиолдолд** л хамгийн ойр байгаа эмнэлэг рүү үнэгүй хүргэж өгөх боломжтой. Үүнийг эмч тогтоосон байх шаардлагатай. Үгүй бол та өөрөө тээвэрлэлтийн зардлыг төлөх хэрэгтэй болж болзошгүй юм.



Бусад зүйл

27. Би машинтай байж болох уу?



Хувьдаа автомашин эзэмших нь үүнтэй холбоотой санхүүгийн зардлаас болоод хэр хэмжээний тусламж шаардлагатай тухай асуудалд, цаашилбал үндсэн хангамжийн хэмжээнд нөлөөлж болох бөгөөд **бүртгүүлэх шаардлагатай!**

28. Миний хүүхдүүд сургуульд явж болох уу?



Австрид 6 – аас 15 хүртэл насны хүүхдүүд заавал сургуульд явах **ёстой**. **Schulbedarfszuschuss** (Хичээлийн хэрэгсэлд нь зориулсан мөнгөн нэмэлт) авч болох талаар өөрийн хариуцагч халамжийн байгууллагадаа хандана уу.

29. Darf ich öffentliche Verkehrsmittel kostenlos benutzen?



Nein!

Benützen Sie ein Verkehrsmittel ohne Fahrschein, ist dies **strafbar**. Die Geldstrafen dafür sind in Österreich sehr hoch.

Für die meisten Verkehrsmittel müssen Sie **vor** Fahrtantritt einen Fahrschein kaufen!

30. Kann ich mich zur freiwilligen Rückkehr entscheiden?



Sollten Sie sich für eine freiwillige Rückkehr in Ihr Heimatland entscheiden, setzen Sie sich bitte mit der **Koordinationsstelle für Ausländerfragen** in Verbindung. Sie wird die **notwendigen Schritte und eine entsprechende finanzielle Unterstützung einleiten**.

29. Би нийтийн тээврийн хэрэгслийг үнэгүй хэрэглэж болох уу?



Болохгүй!

Тээврийн хэрэгсэлд хүчинтэй зорчих билетгүйгээр зорчих нь **хуульд харш**. Үүний мөнгөн торгуулийн хэмжээ Австри улсад маш өндөр байдаг.

Ихэнхи тээврийн хэрэгсэлд суухаасаа **өмнө** зорчих билет худалдаж авах шаардлагатай байдаг.

30. Би сайн дураараа буцах шийдвэр гаргаж болох уу?



Хэрвээ та сайн дураараа эх орондоо буцахаар шийдсэн бол **Koordinationsstelle für Ausländerfragen**-тай холбоо барина уу. Тэрээр **шаардлагатай арга хэмжээ авч, санхүүгийн зохих туслалцаа үзүүлэх талаар хөөцөлдөж өгөх болно**.